ХУУЧИРСАН МЭДЭЭ: 2020/11/18-НД НИЙТЛЭГДСЭН

Даатгалын компаниуд цахимаар ажиллаж байна

IKON.MN
2020 ОНЫ 11 САРЫН 18

Post

IKON.MN

Гэрэл зургийг tpa.mn

Коронавирус (Covid 19)-ийн халдвар манай улсад голомтлон гарсантай холбоотойгоор Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанаар 12 дугаар сарын 1-ний 06.00 цаг хүртэл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан. Үүнтэй холбогдуулан даатгалын компаниуд, мэргэжлийн оролцогчид өөрийн ажилтан болон даатгуулагчдынхаа аюулгүй байдлыг хангах мөн үйл ажиллагаагаа тогтвортой, хурдан шуурхай явуулах зорилгоор цахим хэлбэрээр ажиллаж байна.

Тодруулбал, даатгуулагчдад даатгалын зөвлөгөө мэдээлэл өгөх, нөхөн төлбөрийн баримт материал хүлээн авах, нөхөн төлбөр олгох ажлыг цахим хэлбэрээр явуулснаар шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж даатгуулагч иргэдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаж байгаа юм. Иймд иргэд, аж ахуй нэгж, даатгуулагч Та бүхэн даатгалын компаниуд, мэргэжлийн оролцогчдын лавлах утас, вэб сайт, фэйсбүүк мессенжер буюу чатбот ашиглан тухайн байгууллагаас санал болгосон даатгалын бүтээгдэхүүнүүдийг нь худалдан авах, зөвлөмж мэдээлэл авах, нөхөн төлбөрийн баримт материал бүрдүүлэх боломжтой гэдгийг зөвлөж байна.

Ташрамд мэдээлэхэд, өнөөдрийн байдлаар манай улсын даатгалын зах зээлд ердийн болон урт хугацааны даатгалын нийт 15 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сая гаруй даатгуулагч иргэдэд хүргэж ажилладаг. Даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу даатгагч нь даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд холбогдох баримтыг үндэслэн даатгуулагчид олгох үүрэгтэй.

Даатгалын компаниудын холбогдох утас, фэйсбүүк мессенжер (чатбот)

№	Даатгалын компаниуд	Утас	Чатбот (фейсбүүк)
1	Амар даатгал	1800-2111, 95117965	m.me/amarinsurance
2	Ард даатгал	7720-0089	m.me/ArdInsurance
3	Бодь даатгал	7000-4800	m.me/bodiinsurance.mn
4	Ганзам даатгал	242667, 242668	daatgal@gzd.mn
5	Мандал даатгал	7575-2000	m.me/mandaldaatgal
6	Миг даатгал	7575-6000	m.me/migdaatgal
7	Монгол даатгал	1800-1990	m.me/mongoldaatgal
8	Монре даатгал	77779000	m.me/monreinsurance
9	Мөнх даатгал	94006405, 331332	m.me/munkhinsurance
10	Номин даатгал	1800-2888	m.me/nomininsurance
11	Нейшнл лайф даатгал	7011-3366	m.me/daatgal
12	УБ Хотын даатгал	7000-1234	m.me/ubcityinsurance
13	Практикал даатгал	7777-6677	m.me/PracticalDaatgalOfficial
14	Тэнгэр даатгал	1800-1889	m.me/tengerinsurance
15	Хаан даатгал	7575-7588	m.me/khaandaatgal

Та бүхэн санхүү даатгалын үйлчилгээг цахимаар хүлээн авч, хөл хорионы дэглэмийг сайтар сахиж, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон гэр бүлийнхнээ хамгаалахыг уриалж байна.

Эх сурвалж: **Санхүүгийн зохицуулах хороо**

Анхааруулга

Хэвлэл мэдээллийн байгууллагууд (Телевиз, Радио, Social болон Вэб хуудаснууд) манай мэдээллийг аливаа хэлбэрээр бүрэн ба хэсэгчлэн авч ашиглахдаа эх сурвалжаа (ikon.mn) заавал дурдах ёстойг анхаарна уу!

ЖИРГЭХ | ХУВААЛЦАХ

ЭНЭ МЭДЭЭНД ӨГӨХ ТАНЫ ХАРИУЛАЛ?

2 2

3 СЭТГЭГДЭЛТЭЙ

Нэр...

Сэтгэгдэл...

0/1000

iKon сайтад сэтгэгдэл оруулахад анхаарах зүйлс

НИЙТЛЭХ

ЭХНИЙ | СҮҮЛИЙН | ШИЛДЭГ

Зочин [139.5.219.252] 2020/11/18
Дүүргүүдийн нийгмийн даатгалын газрын ажиллах горим,асуудлаа хэрхэн тавьж шийдвэрлүүлэх, харилцах утас зэргийн дэлгэрэнгүй тодорхой мэдээлийг нийгмийн сүлжээнд тавина уу
0 | 0 Хариулах

Бодох Л Бодол [139.5.219.252] 2020/11/18
Даатгалын компанийдынх шигнийгмийн даатгалаас тэтгэвэр авагчид яаж харилцаж асуудлаа шийдүүлэх талаархи тодорхой мэдээлийг өгнө үү?
0 | 0 Хариулах

Зочин [139.5.219.252] 2020/11/18
Даатгалыги байгууллага гэхээс эрүүл мэнд,нийгмийн даатгалын байгууллага ямар гормоор ажллахвэ? Тэтгэврийн дэвтрээ шинээр нээлгэж авах, банкинд картаа нээлгэх гэх мэт тэтгэвэр авахтай холбоот йсуулыг аяж шидэж байгаа бол?
0 | 0 Хариулах



нийтийн тээврийн автобус иргэдэд үнэгүй үйлчилнэ
7 | 11 | 3 цаг



Ц.Наранзул: Нийт хүн амын 69 хувьд томуу, томуу төст өвчин үүсгэгч вирусийн тархалт байна
2 | 12 | 3 цаг

Шинэ жилийн онцлох кампанит ажил
2 | 3 цаг

ЕБС-ийн 2,565 сурагчид гадаадад сурах мэдээллийг үнэ төлбөргүй хүргэлээ
25 | 3 цаг

Украины цэргүүд анх удаа тулааны талбараас Умард Солонгосын цэргийг олзолжээ
65 | 161 | 4 цаг

LIVE 11:37
Б.Дэлгэрсайхан: Төмөр замаа холбосон ч машинаар тээвэрлэх нүүрсний тоо хэмжээг бууруулахгүй

ТААЛАХ | ДАГАХ | ХОЛБОХ

© 2024 Бенекрафт ХХК